

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2022 оны тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2023/04/НА-СТА-ТӨА

| | |
|---|--|
| <p>Цахим хуудас: www.audit.mn Эрдэнэт хот 2023 он</p> | <p>Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn Аудитын менежер: Б.Буян-Ундрах Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Оргилмөрөн Утас: 70357955 Цахим хаяг: orgilmurung@audit.gov.mn</p> |
|---|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2023.03.17 № 95
танай _____-ны № _____-т

ЭРДЭНЭТ БУЛГАНЫ
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ В.АДЪЯА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2 дэд захирлыг ажлаас нь чөлөөлж, орон тоог цомхотгож, 80.1 сая төгрөгийн тэтгэмж олгосон, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр Тоёота Ланд Круйзер 200 маркийн 388.7 сая төгрөгийн анхны өртөгтэй 3 автомашиныг бусад байгууллагад балансаас баланст шилжүүлсэн байна.

Дэлхийн банкны “Эрчим хүчний төсөл-2”-оор гүйцэтгэсэн Архангай 10/0.4 кВ-ын цахилгаан хангамжийн шинэчлэлийн ажлыг 4,057.3 сая төгрөгөөр, борлуулалт, арилжааны Edimis-2.0 системийг 264.2 сая төгрөгөөр бүртгэж авсан байна.

Тайлант онд 1,269.8 сая кВт.ц буюу 268,119.0 сая төгрөгийн цахилгаан эрчим хүч борлуулсны 82.3 хувийг уул уурхайн хэрэглэгчийн борлуулалт, 9.9 хувийг үйлдвэр, аж ахуй нэгж, төсөвт газрын борлуулалт, 7.8 хувийг ахуйн хэрэглэгчийн борлуулалт эзэлж байна. Үүнээс гадна түгээх үйлчилгээний 23,694.2 сая, бусад үйл ажиллагааны бус 1,236.1 сая төгрөгийн орлого олж төлөвлөгөөг 14,983.8 сая төгрөгөөр давуулж ажилласан байна.

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас авах авлага 8,473.6 сая төгрөгөөр буурч 10,483.2 сая төгрөг болсон нь нийт авлагын эцсийн үлдэгдэл 12,423.5 сая төгрөгийн 84.4 хувийг дангаар эзэлж, оны эхнээс цахилгаан эрчим хүчний авлага 8,119.1 сая төгрөг буюу 58.7 хувиар, нийт авлага 11,220.0 сая төгрөгөөр буурахад голчлон нөлөөлсөн бөгөөд тайлант оны эцэст нийт авлага зорилтот түвшний үзүүлэлтийн төлөвлөгөөнөөс 119.1 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

“Эрчим хүчний төсөл-2” төслийн хүрээнд санхүү хүний нөөцийн VERITECH ERP системийг 2022 онд бүрэн нэвтрүүлж, санхүүгийн тайлангаа гаргасан байна.

Аудитын гол асуудал

Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 659 дүгээр тогтоолоор “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2022 онд мөрдөх цахилгаан түгээлтийн алдагдлыг шинийн түгээлтийг хассан дүнгээр 15.55 (нийт түгээлтээр 3.55) хувиар тогтоосон бөгөөд гүйцэтгэлээр 13.08 (нийт түгээлтээр 3.13) хувийн алдагдалтай ажиллаж, тогтоосон нормоос 6.1 сая кВт.ц буюу 1,046.5 сая төгрөгийн цахилгаан эрчим хүч хэмнэжээ.

Цахим төлбөр тооцооны систем нэвтрүүлсэн, түүнтэй зохицон ажиллах E-Киоск төхөөрөмжийг нэмэгдүүлж салбар бүрд байршуулснаар жилийн эцсийн дүнгээр нийт төлбөр төлж буй хэрэглэгчдийн 62 хувь нь цахимаар эрчим хүчний төлбөрөө төлсөн байна.

Бусад асуудлын хэсэг

“Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн нь чанарын тогтолцооны ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлж, стандарт нэвтрүүлэх ажлын хэсэг томилж сургалтад хамруулсан ба ажилтнуудад ерөнхий ойлголт өгөх сургалт зохион байгуулсан. Мөн дүрэм, журам, ажлын зааврыг стандартын хэлбэрт шилжүүлэх, ажлын зураглал үйлдэх ажлуудыг хийж хэрэгжүүлж байна.

Монгол Улсын эрчим хүчний салбар, бүс нутгийн цахилгаан хангамжийг нэмэгдүүлэх, түгээх компаниудын цахилгаан эрчим хүчний алдагдлыг бууруулж, эдийн засгийн чадавхыг сайжруулах, техникийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон улсын Хөгжлийн Ассоциаци хооронд байгуулсан хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн 54.4 сая ам.долларын “Эрчим хүчний төсөл-2” хэрэгжиж байна.

Энэхүү төслийн хүрээнд Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-д хамаарах 16.2 сая ам.долларын барилга угсралт, хөрөнгө оруулалтын ажлууд 2018 оноос эхэлж 2022 оны жилийн эцсийн байдлаар эдгээр ажлын гүйцэтгэл 70.5 хувьтай, гүйцэтгэлийн санхүүжилтэд нийт 11.4 сая ам.долларыг Дэлхийн банкнаас гүйцэтгэгч компаниудад олгосон бөгөөд төсөл хэрэгжүүлж дуусгах хугацааг 2023 оны 08-р сарын 01-ний өдрийг хүртэл гэрээг сунгасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-----------------|---|---------------------------|---------------------------|
| 1 | ХӨРӨНГӨ | | |
| 1.1 | Эргэлтийн хөрөнгө | | |
| 1.1.1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 1,483,954,128.55 | 532,172,329.28 |
| 1.1.2 | Дансны авлага | 23,523,861,201.29 | 12,250,634,707.08 |
| 1.1.3 | Татвар, НДШ – ийн авлага | 90,026,262.42 | 92,130,402.31 |
| 1.1.4 | Бусад авлага | 28,470,624.44 | 81,310,452.18 |
| 1.1.5 | Бусад санхүүгийн хөрөнгө | | |
| 1.1.6 | Бараа материал | 3,808,700,311.24 | 4,417,165,568.65 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 2,889,952,242.08 | 12,239,631,658.47 |
| 1.1.8 | Бусад эргэлтийн хөрөнгө | | |
| 1.1.9 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) | | |
| 1.1.10 | Салбар хоорондын тооцооны авлага | | |
| 1.1.20 | Эргэлтийн хөрөнгийн дүн | 31,826,148,133.36 | 29,612,513,441.73 |
| 1.2 | Эргэлтийн бус хөрөнгө | | |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 140,050,918,184.09 | 139,141,753,013.87 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 2,989,749,190.09 | 3,534,473,613.69 |
| 1.2.3 | Биологийн хөрөнгө | 0 | 0 |
| 1.2.4 | Урт хугацаат хөрөнгө оруулалт | 0 | 0 |
| 1.2.6 | Хойшлогдсон татварын хөрөнгө | 980,130,838.13 | 1,334,323,110.50 |
| 1.2.7 | Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | | |
| 1.2.8 | Бусад эргэлтийн бус хөрөнгө | | |
| 1.2.9 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) | | |
| 1.2.20 | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 144,020,798,212.31 | 144,010,549,738.06 |
| 1.3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 175,846,946,345.67 | 173,623,063,179.79 |
| 2 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ | | |
| 2.1. | Өр төлбөр | | |
| 2.1.1 | Богино хугацаат өр төлбөр | | |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 21,353,583,324.64 | 9,320,178,292.11 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | 1,741,597.16 | 93,220,626.04 |
| 2.1.1.3 | Татварын өр | 218,061,463.03 | 481,406,668.44 |
| 2.1.1.4 | НДШ - ийн өглөг | 4,358,082.96 | 59,161,020.80 |
| 2.1.1.5 | Богино хугацаат зээл | | |
| 2.1.1.6 | Хүүгийн өглөг | 159,782,725.22 | 889,744,337.42 |
| 2.1.1.7 | Ногдол ашгийн өглөг | | |
| 2.1.1.8 | Урьдчилж орсон орлого | 309,240,423.72 | 240,746,776.40 |
| 2.1.1.9 | Нөөц /өр төлбөр/ | | |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | 90,274,515.16 | 219,724,785.97 |
| 2.1.1.11 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр | | |
| 2.1.1.12 | Салбар хоорондын тооцооны өглөг | | |
| 2.1.1.13 | Богино хугацаат өр төлбөрийн дүн | 22,137,042,131.89 | 11,304,182,507.18 |
| 2.1.2 | Урт хугацаат өр төлбөр | | |
| 2.1.2.1 | Урт хугацаат зээл | 21,227,329,712.71 | 39,316,374,919.69 |
| 2.1.2.2 | Нөөц /өр төлбөр/ | 23,488,395.19 | 33,127,848.01 |

| | | | |
|----------------|---------------------------------------|---------------------------|---------------------------|
| 2.1.2.3 | Бусад урт хугацаат өглөг | 3,082,005,912.60 | 3,062,174,520.97 |
| 2.1.2.4 | Хойшлогдсон татварын өр | 5,850,137,732.12 | 5,449,198,656.48 |
| 2.1.2.5 | Урт хугацаат өр төлбөрийн дүн | 30,182,961,752.62 | 47,860,875,945.15 |
| 2.2 | Өр төлбөрийн нийт дүн | 52,320,003,884.51 | 59,165,058,452.33 |
| 2.3 | Эздийн өмч | | |
| 2.3.1 | Өмч: - төрийн | 48,120,648,100.00 | 48,120,648,100.00 |
| 2.3.2 | - хувийн | | |
| 2.3.3 | - хувьцаат | | |
| 2.3.4 | Нэмж төлөгдсөн капитал | | |
| 2.3.6 | Халаасны хувьцаа | | |
| 2.3.5 | Нэмж төлөгдсөн капитал | | |
| 2.3.7 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 82,772,079,052.45 | 82,785,285,667.29 |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | 2,812,142,660.00 | 2,922,450,460.00 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | (10,177,927,351.29) | (19,370,379,499.83) |
| 2.3.11 | Эздийн өмчийн дүн | 123,526,942,461.16 | 114,458,004,727.46 |
| 2.4 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН | 175,846,946,345.67 | 173,623,063,179.79 |

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---------------|---|---------------------------|---------------------------|
| 1 | Борлуулалтын орлого (Цэвэр) | 269,396,897,140.99 | 291,813,206,474.01 |
| 2 | Борлуулалтын өртөг | 257,391,358,190.26 | 281,330,533,087.38 |
| 3 | Нийт ашиг (алдагдал) | 12,005,538,950.73 | 10,482,673,386.63 |
| 4 | Түрээсийн орлого | 21,600,000.00 | 21,600,000.00 |
| 5 | Хүүгийн орлого бусад | | |
| 6 | Ногдол ашгийн орлого | | |
| 7 | Эрхийн шимтгэлийн орлого | | |
| 8 | Бусад орлого | 449,718,079.02 | 1,204,693,098.86 |
| 9 | Борлуулалт маркетингийн зардал | 4,540,894,655.89 | 6,206,759,574.06 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 8,107,794,214.37 | 9,208,944,304.21 |
| 11 | Санхүүгийн зардал | 131,662,163.87 | 313,638,736.05 |
| 12 | Бусад зардал | 395,592,611.42 | 336,804,355.49 |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | (366,151.00) | (5,281,034,216.46) |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | (2,693,611.39) | (142,598,246.51) |
| 15 | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | |
| 16 | Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз) | | |
| 17 | Бусад ашиг (алдагдал) | | |
| 18 | Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | (702,146,378.19) | (9,780,812,947.29) |
| 19 | Орлогын татварын зардал | - | - |
| 19.1 | Хойшлогдсон татварын зардал (орлого) | 196,256,391.01 | (583,763,628.69) |
| 20 | Татварын дараах ашиг (алдагдал) | (898,402,769.20) | (9,197,049,318.60) |
| 21 | Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) | - | - |
| 22 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | (898,402,769.20) | (9,197,049,318.60) |
| 23 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | 40,045,089.88 | 13,206,614.84 |
| 24 | Орлогын нийт дүн | (858,357,679.32) | (9,183,842,703.76) |

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|--|--------------------------|-------------------------------------|---------------------------|----------------------------|---------------------------|
| 2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 41,896,959,300.00 | 82,711,275,017.35 | 2,812,142,660.00 | (4,395,778,483.18) | 123,045,357,439.39 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | (4,883,746,098.91) | (4,883,746,098.91) |
| Залруулсан үлдэгдэл | 41,896,959,300.00 | 82,711,275,017.35 | 2,812,142,660.00 | (9,279,524,582.09) | 118,161,611,340.48 |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | (898,402,769.20) | (898,402,769.20) |
| Бусад дэлгэрэнгүй орлого | | 40,045,089.88 | | | 40,045,089.88 |
| Өмчид гарсан өөрчлөлт | 6,223,688,800.00 | | | | 6,223,688,800.00 |
| 2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 48,120,648,100.00 | 82,772,079,052.45 | 2,812,142,660.00 | (10,177,927,351.29) | 123,526,942,461.16 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | 0 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Залруулсан үлдэгдэл | 0 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 0 | 0.00 | 0.00 | (9,197,049,318.60) | (9,197,049,318.60) |
| Бусад дэлгэрэнгүй орлого | 0 | 17,803,784.90 | 0.00 | 4,597,170.06 | 22,400,954.96 |
| Өмчид гарсан өөрчлөлт | 0 | 0.00 | 110,307,800.00 | 0.00 | 110,307,800.00 |
| Зарласан ногдол ашиг | 0 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | 0 | (4,597,170.06) | 0.00 | 0.00 | (4,597,170.06) |
| 2022 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл | 48,120,648,100.00 | 82,785,285,667.29 | 2,922,450,460.00 | (19,370,379,499.83) | 114,458,004,727.46 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Д/д | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|--|---------------------------|---------------------------|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 1.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 287,938,585,273.23 | 339,638,654,057.98 |
| 1.1.1 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 260,908,773,913.91 | 306,233,724,954.72 |
| 1.1.2 | Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | | |
| 1.1.3 | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | | 400,000.00 |
| 1.1.4 | Буцаан авсан албан татвар | | |
| 1.1.5 | Татаас, санхүүжилтийн орлого | 25,867,476,496.54 | 29,724,854,976.89 |
| 1.1.6 | Бусад мөнгөн орлого | 1,162,334,862.78 | 3,679,674,126.36 |
| 1.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 285,738,681,564.14 | 338,635,114,171.73 |

| | | | |
|------------|---|---------------------------|---------------------------|
| 1.2.1 | Ажиллагчдад төлсөн | 9,555,427,018.72 | 12,517,220,846.85 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 2,996,757,617.70 | 3,806,478,555.56 |
| 1.2.3 | Бараа материал худалдан авахад төлсөн | 265,756,884,265.97 | 313,028,908,082.97 |
| 1.2.4 | Ашиглалтын зардалд төлсөн | 106,607,988.78 | 96,580,332.67 |
| 1.2.5 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 1,261,117,132.66 | 1,466,370,832.26 |
| 1.2.6 | Хүүгийн төлбөрт төлсөн | 606,386,405.71 | 453,495,316.11 |
| 1.2.7 | Татварын байгууллагад төлсөн | 2,986,006,233.91 | 3,138,055,690.60 |
| 1.2.8 | Даатгалын төлбөрт төлсөн | 20,602,705.00 | 19,030,151.00 |
| 1.2.9 | Бусад мөнгөн зарлага | 2,448,892,195.69 | 4,108,974,363.71 |
| 1.3 | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 2,199,903,709.09 | 1,003,539,886.25 |
| 2 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 2.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 3,300,000.00 | 8,200,000.00 |
| 2.1.1 | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | 3,300,000.00 | 8,200,000.00 |
| 2.1.2 | Биет бус хөрөнгө борлуулсны орлого | | |
| 2.1.3 | Хөрөнгө оруулалт борлуулсны орлого | | |
| 2.1.4 | Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого | | |
| 2.1.5 | Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | | |
| 2.1.6 | Хүлээн авсан хүүгийн орлого | | |
| 2.1.7 | Хүлээн авсан ногдол ашиг | | |
| 2.1.8 | ХО бусад мөнгөн орлого | | |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 2,072,711,267.00 | 1,960,416,313.32 |
| 2.2.1 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 2,052,811,267.00 | 1,808,804,637.32 |
| 2.2.2 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 19,900,000.00 | 151,611,676.00 |
| 2.2.3 | Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | | |
| 2.2.4 | Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | | |
| 2.2.5 | Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | | |
| 2.2.6 | ХО бусад мөнгөн зарлага | | |
| 2.3 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (2,069,411,267.00) | (1,952,216,313.32) |
| 3 | Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | | |
| 3.1 | Мөнгөн орлогын дүн (+) | | |
| 3.1.1 | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | | |
| 3.1.2 | Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | | |
| 3.1.3 | Төрөл бүрийн хандив | | |
| 3.1.4 | Бусад мөнгөн орлого | | |
| 3.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 1,552,686.00 | 3,105,372.20 |
| 3.2.1 | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | 1,552,686.00 | 3,105,372.20 |
| 3.2.2 | Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | | |
| 3.2.3 | Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн | | |
| 3.2.4 | Төлсөн ногдол ашиг | | |
| 3.2.5 | Бусад мөнгөн зарлага | | |
| 3.3 | Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (1,552,686.00) | (3,105,372.20) |
| 4 | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | 128,939,756.09 | (951,781,799.27) |
| 4 | Валютын ханшийн зөрүү | | |

| | | | |
|---|---|------------------|------------------|
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 1,355,014,372.46 | 1,483,954,128.55 |
| 6 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 1,483,954,128.55 | 532,172,329.28 |

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

| Д/д | Үзүүлэлт | хэмжих нэгж | 2021 оны гүйцэтгэл | 2022 оны | | Зөрүү | | |
|-----|--|------------------------------|--------------------|------------------|------------------|------------------|-----------------|--------------|
| | | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | биет | хувь | |
| 1 | Худалдаж авсан цахилгаан | сая.кВтц | 1,256.5 | 1,303.9 | 1,310.9 | 7.0 | 0.5% | |
| 2 | ЦЭХ-ний алдагдал | хувиар | % | 3.77% | 3.55% | 3.13% | -0.42% | |
| | | биетээр | сая.кВтц | 47.4 | 46.3 | 41.1 | -5.2 | -11.3% |
| 3 | Борлуулах цахилгаан эрчим хүч | сая.кВтц | 1,209.1 | 1,257.6 | 1,269.8 | 12.2 | 1.0% | |
| 4 | Нийт орлого | | сая.төг | 269,870.8 | 278,065.5 | 293,049.3 | 14,983.8 | 5.4% |
| | Үүнээс: | Борлуулалтын орлого | сая.төг | 245,566.5 | 253,537.7 | 268,119.0 | 14,581.4 | 5.8% |
| | | Түгээх үйлчилгээний орлого | сая.төг | 23,830.4 | 23,694.2 | 23,694.2 | 0.0 | 0.0% |
| | Үйл ажиллагааны бус орлого | сая.төг | 473.9 | 833.7 | 1,236.1 | 402.4 | 48.3% | |
| 5 | Нийт зардал | | сая.төг | 270,572.9 | 285,824.8 | 302,830.1 | 17,005.4 | 5.9% |
| | Үүнээс: | Худалдаж авсан ЦЭХ-ний өртөг | сая.төг | 242,967.1 | 251,226.2 | 263,280.4 | 12,054.3 | 4.8% |
| | | Үйл ажиллагааны зардал | сая.төг | 27,204.6 | 34,160.8 | 33,779.4 | -381.4 | -1.1% |
| | | Үйл ажиллагааны бус зардал | сая.төг | 400.8 | 437.8 | 489.2 | 51.4 | 11.7% |
| | Валютын ханшийн алдагдал | сая.төг | 0.4 | 0.0 | 5,281.0 | 5,281.0 | | |
| 6 | Татварын өмнөх ашиг /алдагдал/ | сая.төг | -702.1 | -7,759.2 | -9,780.8 | -2,021.6 | 26.1% | |
| 7 | Татварын дараах ашиг /алдагдал/ | сая.төг | -898.4 | -7,759.2 | -9,197.0 | -1,437.8 | 18.5% | |
| 8 | Борлуулалтын орлогын 1 төг-т ногдох зардал | төгрөг | 1.00 | 1.03 | 1.03 | 0.01 | 0.5% | |
| 9 | Нийт авлага | | сая.төг | 23,643.5 | 12,542.6 | 12,423.5 | -119.1 | -0.9% |
| | Үүнээс: | ЦЭХ-ний | сая.төг | 23,523.5 | 12,432.6 | 12,250.1 | -182.5 | -1.5% |
| | | Бусад | сая.төг | 120.0 | 110.0 | 173.4 | 63.4 | 57.7% |
| 10 | Нийт өглөг | | сая.төг | 52,320.0 | 58,454.4 | 59,165.1 | 710.7 | 1.2% |
| | Үүнээс: | Богино хугацаат өр төлбөр | сая.төг | 22,137.0 | 13,410.6 | 11,304.2 | -2,106.4 | -15.7% |
| | | Урт хугацаат өр төлбөр | сая.төг | 30,183.0 | 45,043.8 | 47,860.9 | 2,817.1 | 6.3% |
| 11 | Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ | сая.төг | 4,582.5 | 5,610.0 | 4,501.1 | -1,108.9 | -19.8% | |
| 12 | Нийт ажиллагсдын тоо | хүн | 658 | 655 | 655 | 0.0 | 0.0% | |
| 13 | Нийт цалингийн сан | сая.төг | 10,998.6 | 14,771.8 | 14,600.7 | -171.1 | -1.2% | |

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 344.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 27.4 сая төгрөгийн 6 төлбөрийн акт тогтоож, 234.2 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 83.1 сая төгрөгийн 5 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Өмнөх санхүүгийн аудитаар тогтоосон 8.0 сая төгрөгийн төлбөрийн актыг компаниас төлснөөр компанид давхар хохирол учруулж, тус дүнгээр тайлант онд 7 харилцагчаас хүлээн зөвшөөрөхүйц бус авлага бүртгэсэн байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 84.4-д "Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй", 84.4.3-д "компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах", 84.6-д "Компанийн эрх бүхий албан тушаалтан нь энэ хуулийн 84.4, 84.5-д заасан үүргээ биелүүлээгүй, удаа дараа зөрчсөнөөс компанид хохирол учруулсан бол учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Компанийн дансанд төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвшөөрлөөр Тоёота Лексус-470 маркийн автомашиныг дуудлага худалдаагаар 15.1 сая төгрөгөөр худалдсан боловч, дараагийн өдөр нь худалдан авагч нь дэнчингийн 2.0 сая төгрөгийг суутгуулж худалдан авсан автомашинаа буцаах хүсэлт гаргаснаар 13.1 сая төгрөгийг нь буцаан олгосон. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэргүй, төрийн өмчийн захиргааны байгууллагын төлөөлөгчгүйгээр дахин дуудлага худалдааг зохион байгуулж тус автомашиныг 8.2 сая төгрөгөөр худалдаж компанид 4.9 сая төгрөгийн хохирол учруулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 41.3-д "Дуудлагын худалдаанд түүнийг эхлэхээс дуусах хүртэл төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төлөөлөгч заавал байлцаж дараах үүрэг гүйцэтгэнэ", 42 дугаар зүйлд "Дор дурдсан үндэслэлийн аль нэг байвал дуудлагын худалдааг хууль зөрчин явуулсан гэж тооцно", 42.4-д "хорооны төлөөлөгчгүйгээр эхэлсэн, явуулсан", 44.2-д "Дуудлагын худалдааг дахин явуулах тухай шийдвэрийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гаргах бөгөөд дахин дуудлагын худалдаа явуулах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө энэ тухай мэдээлнэ. Дуудлагын худалдаа дахин явуулахдаа энэ хуульд заасан журмыг баримтална", 45 дугаар зүйлд "Дуудлагын худалдааны явцад үүссэн маргааныг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шийдвэрлэнэ. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрийг зөвшөөрөхгүй бол шүүхэд гомдол гаргаж болно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд батлагдсан 2 ширхэг дроныг "Чандмань суурь комплект" ХХК-с баталгаат хугацааны засвар үйлчилгээний үнэд 1.8 сая төгрөгийг нэмж төлөн худалдаж авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6.1-д "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", Компанийн тухай хуулийн 84.4-д "Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй", 84.4.3-д

"компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах", 84.6-д "Компанийн эрх бүхий албан тушаалтан нь энэ хуулийн 84.4, 84.5-д заасан үүргээ биелүүлээгүй, удаа дараа зөрчсөнөөс компанид хохирол учруулсан бол учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө", "Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 06 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн дүрмийн 8.11-д "Гүйцэтгэх захирал дор дурдсан үүрэг хүлээж, эрх эдэлнэ", 8.11.5-д "Гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэх, удирдаж буй компанийн санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг явуулах" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

Тус компани нь Ранчо ХХК-тай 2022.02.10-ны өдөр "Цэвэршүүлсэн ус худалдан авах" 5.9 сая төгрөгийн 1 жилийн гэрээг байгуулж 2022.03.04-2023.02.07-ны хооронд нийт 9.3 сая төгрөгийн худалдан авалт хийж гэрээний дүнгээс 3.4 сая төгрөг илүү шилжүүлсэн байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 84.4-д "Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй", 84.4.3-д "компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах", 84.6-д "Компанийн эрх бүхий албан тушаалтан нь энэ хуулийн 84.4, 84.5-д заасан үүргээ биелүүлээгүй, удаа дараа зөрчсөнөөс компанид хохирол учруулсан бол учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө", "Цэвэршүүлсэн ус худалдан авах" ЭБЦТС/Ш/03/2022 тоот гэрээний 6.1-д "Энэхүү гэрээ нь дор дурдсан үндэслэлээр дуусгавар болно", 6.1.1-д "Энэхүү гэрээ нь нийлүүлэгч 5,855.0 мянган төгрөгийн барааг бүрэн нийлүүлэх, эсхүл 1 жилийн хугацаа дуусах хоёрын аль түрүүлж дуусгавар болох үе хүртэл хэрэгжинэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

Санхүү нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогчид ажил хавсарсны 40 хувийн нэмэгдлийг 0.4 сая төгрөгөөр илүү олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 56.1-д "Ажил олгогч нь ажилтантай тохиролцсоноор ажил хослон гүйцэтгүүлэх, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, ажилтны ажлын цагт багтаан өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгүүлэх, ажлын ачааллыг нэмэгдүүлэх хэлбэрээр ажиллуулж болно", 56.2-д "Энэ хуулийн 56.1-д заасны дагуу ажиллах ажилтанд гүйцэтгэх ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг нэмж олгоно" гэж заасантай нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн албан тушаалтнуудад сар, жилийн үр дүнгийн урамшуулалтай давхардуулан, журамд заасан үндсэн үзүүлэлтийг үнэлж дүгнэлгүй, шийдвэргүйгээр 8.8 сая төгрөгийн балансын урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Компанийн тухай хуулийн 84.4-д "Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй", 84.4.1-д "хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1-д "Захирал дараах эрх, үүрэгтэй", 20.1.2-д "үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах", Гүйцэтгэх захирлын 2021 оны А/186 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан "Санхүү, нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудыг шагнах тухай журам"-ын 2.1-д "... компанийн болон салбарын санхүү, нягтлан бодох бүртгэлийн ажилтны ажлыг дүгнэж,

ажлын үр дүн, хагас жил болон жилийн эцсийн санхүүгийн тайлангийн хугацаатай уялдуулан хагас жил тутамд шагнаж урамшуулж болно" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

Тайлант оны эцэст нийт албан хаагчдад цалингийн хэмнэлт 172.1 сая төгрөгийг илүү цагийн цалин хэлбэрээр олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 91.1-д "Ажилтныг ажил олгогчийн санаачилгаар ердийн ажлын өдрийн үргэлжлэл, ээлжийн ажлын цаг, долоо хоногийн ажлын цагийн үргэлжлэл болон ажлын цагийг нэгтгэн бодох ердийн ажлын цагийн нийлбэрээс хэтрүүлэн ажиллуулахыг илүү цагаар ажилласанд тооцно.", 91.3-д "Ажлын бүтэн бус цагаар ажиллах хөдөлмөрийн гэрээнд заасан ажлын цагийг ажил олгогчийн санаачилгаар хэтрүүлэн ажиллуулахыг илүү цагаар ажилласанд тооцно.", 91.2.4-д "урьдчилан мэдэх боломжгүй бөгөөд яаралтай гүйцэтгэхгүй бол аж ахуйн нэгж, байгууллагын буюу түүний салбар, нэгжийн хэвийн үйл ажиллагаанд учирч болзошгүй саадаас урьдчилан сэргийлэх, эсхүл учирсан саадыг арилгахад чиглэгдсэн хойшлуулшгүй ажил гүйцэтгэх" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад сар, жилийн үр дүнгийн урамшуулалтай давхардуулан, шийдвэргүйгээр 62.1 сая төгрөгийн балансын урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Компанийн тухай хуулийн 84.4-д "Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй", 84.4.1-д "хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1-д "Захирал дараах эрх, үүрэгтэй", 20.1.2-д "үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах", Гүйцэтгэх захирлын 2021 оны А/186 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан "Санхүү, нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудыг шагнах тухай журам"-ын 2.1-д "... компанийн болон салбарын санхүү, нягтлан бодох бүртгэлийн ажилтны ажлыг дүгнэж, ажлын үр дүн, хагас жил болон жилийн эцсийн санхүүгийн тайлангийн хугацаатай уялдуулан хагас жил тутамд шагнаж урамшуулж болно" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Шатахууны худалдан авалттай холбоотойгоор "Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК -аас шилжүүлсэн мөнгийг шатахууны ерөнхий картад хүлээн авч мөнгөн хөрөнгөөр, ерөнхий картаас шатахуун худалдан авах дэд картуудад цэнэглэлт хийхдээ урьдчилж төлсөн зардлаар, дэд картуудын худалдан авалтыг бараа материалаар бүртгэж, шатахууныг зарцуулж байгаа буюу тайлант оны жилийн эцсийн шатахууны ерөнхий картын 49.0 сая төгрөгийг харилцах дансны мөнгөн хөрөнгийн үлдэгдлээр тайлагнасан байна.

Энэ нь НББОУС-н шаардлага болон Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан "Аж ахуйн нэгжид мөрдөгдөх санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын 1-д "Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөд - Касс болон банкны харилцах дансанд байгаа мөнгө, хугацаагүй хадгаламж, 3 сар хүртэлх хугацаагаар хязгаарласан тусгай зориулалт бүхий мөнгөн сан, үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг, хөрвөх чадвар сайтай богино хугацаатай хөрөнгө оруулалт хамаарна. Эдгээр хөрөнгийг нэрлэсэн үнээр нь бүртгэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Хөрвөх чадварын шаардлага хангахгүй, зөвхөн шатахуун худалдан авахад зориулагдсан шатахууны картын үлдэгдлийг мөнгөн хөрөнгөөс хасаж, тохирох дансанд хүлээн зөвшөөрч бүртгэж, тайлагнах.

2. Авлага, өр төлбөрийн данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Тооцоо нийлсэн актыг тооцооны баримтын жагсаалт хөтлөхгүйгээр үйлдэж баталгаажуулсан, борлуулалтын цикл, үйл ажиллагаанаас үүссэн хэрэглэгчдээс авах авлагатай хамааралгүй болон тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, цалин хөлс, шагнал урамшуулал олголт, суутгал, ХХОАТ-ын тайлан, хөнгөлөлтөөс үүссэн, удирдах, хянах боломжтой ажилчидтай холбоотой авлага, өр төлбөр үүсгэсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.3-д "Харилцагч талуудын хооронд гарсан ажил гүйлгээг тодруулан тайлант үеийн эцэс дэх хоорондын тооцооны үлдэгдлийг баталгаажуулахдаа улирал, жилийн эцэст харилцагч талууд тооцооны үлдэгдлийн баталгааг үйлдэнэ. Шаардлагатай бол санхүүгийн тайлангийн дундуур хийж болно. Тооцооны үлдэгдлийн баталгааг тооцоо үүссэн данс тус бүрээр хөтөлнө. 2 байгууллагын тооцооны баримтыг тооцооны үлдэгдлийн баталгааны хавсралтад нэгтгэж гаргана" гэж заасантай нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: ЦЭХ-ий төлбөртэй хамааралгүй, ажил гүйлгээний явцад үүсээгүй, тооцооны үлдэгдлийн баталгаагүй авлага, өр төлбөр бүртгэхийг таслан зогсоож, тооцоо нийлсэн актыг тооцооны баримтын жагсаалттай хамт үйлдэж хэвших.

3. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд "Орлого авлагын автоматжуулсан, гар утасны программ хангамж нэвтрүүлэх, төсөвт өртөг 20.0 сая төгрөг" нэрээр батлагдсан төсвөөр, "Орлого авлагын автоматжуулсан, гар утасны программ хангамж нэвтрүүлэх" гэсэн гэрээ байгуулан, гэрээг дүгнэсэн акт үйлдэж Е-Киоск төхөөрөмж 2 ширхгийг худалдаж авсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.1-д "Улсын болон орон нутгийн төсвөөс хөрөнгө оруулалтаас бусад зардалд хуваарилсан хөрөнгө, бусад эх үүсвэр, түүнчлэн өөрийн хөрөнгөөр санхүүжигдэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг захиалагч энэ хуульд заасан журмын дагуу зохион байгуулна", Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах

журам"-ын 4.5-д "Батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, зохих ёсоор хэрэгжүүлээгүй үндэслэл, тайлбарыг тайланд тусгана" гэж заасантай нийцэхгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж батлуулахгүйгээр төсөл, арга хэмжээний зориулалтыг өөрчлөн худалдан авах ажиллагааг зохион байгуулахгүй байх.

4. Цалингийн данстай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт:

Тайлант онд гүйцэтгэх захирлын шийдвэргүйгээр амралттай байх хугацаандаа ажилласан ажилтнуудын цалинд 12 сард 11.4 сая төгрөг илүү цагаар олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 91.1-д "Ажилтныг ажил олгогчийн санаачилгаар ердийн ажлын өдрийн үргэлжлэл, ээлжийн ажлын цаг, долоо хоногийн ажлын цагийн үргэлжлэл болон ажлын цагийг нэгтгэн бодох ердийн ажлын цагийн нийлбэрээс хэтрүүлэн ажиллуулахыг илүү цагаар ажилласанд тооцно", 91.2.4-д "урьдчилан мэдэх боломжгүй бөгөөд яаралтай гүйцэтгэхгүй бол аж ахуйн нэгж, байгууллагын буюу түүний салбар, нэгжийн хэвийн үйл ажиллагаанд учирч болзошгүй саадаас урьдчилан сэргийлэх, эсхүл учирсан саадыг арилгахад чиглэгдсэн хойшлуулшгүй ажил гүйцэтгэх" гэж заасныг зөрчсөн байна.

4.2 Өгсөн зөвлөмж: Ажилтны ээлжийн амралтыг биеэр эдлүүлэх бүх талын арга хэмжээг авч, ажлын зайлшгүй шаардлагаар дуудаж ажиллуулсан, нөхөн амраах боломжгүй бол цалин хөлсийг хууль, журмын хүрээнд тооцож олгох.

5. Цалингийн данстай холбоотой асуудал

5.1 Илрүүлэлт:

Ерөнхий нягтлан бодогчид мэргэшсэн нягтлан бодогчийн болон татварын мэргэшсэн зөвлөхийн нэмэгдлийг тус бүр цалингийн 15 хувиар тогтоон олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.7-д "мэргэшсэн нягтлан бодогч - гэж мэргэшсэн нягтлан бодогчийн эрх авсан мэргэжлийн нягтлан бодогч, санхүүч, эдийн засагчийг", 23.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын шийдвэрээр нягтлан бодох бүртгэлийн ажилтанд мэргэшсэн эрхийн нэмэгдэл олгож болно", Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийн 3.1.4-д "татварын мэргэшсэн зөвлөх - гэж татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх авсан, татварын итгэмжлэгдсэн хуулийн этгээдэд ажиллах татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийг", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

5.2 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн ажилтанд мэргэшсэн зэргийн нэмэгдлийг давхардуулан олгохгүй байх.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|------------------|-------------|--------------|---------------|-------------|-----------------|--------------|----------|-------------|--------------------------------------|---------------------|---|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| ЭБЦТС ТӨХК | 13 | 344.6 | 6 | 27.3 | 2 | 234.2 | 5 | 83.1 | | | | |
| Дүн | 13 | 344.6 | 6 | 27.3 | 2 | 234.2 | 5 | 83.1 | | | | |

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|-----------------------------|--------------------------|-----------------------------|--------------------|-----------------|-------------------------|----------------|-------|----------------------------|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | | | | |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТБОНӨААН | 1 | 1 | | | 1 | | | |
| | НИЙТ | 1 | 1 | | | 1 | | | |